

Монгол суваргын утга, бэлгэдэл

Диваагийн Тайвансайхан

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Жигдэнгомбын Цэзэн ✉

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс

✉ j.tsezen.amjilt@gmail.com

Хураангуй: “Суварга” үүссэн товч тойм хийгээд түүний шинж, утга бэлгэдлийн илэрхийлэл, суваргын агуулга, хэлбэрийн талаар товч өгүүлнэ.

Бурхан Будда энэ дэлхийд мэндэлсэн үетэй холбогдон анхны томоохон суваргууд үүсэж буй болсон тодорхой нэр, цаг үе, улс орнуудыг нэрлэнэ. Үүнд: Бурхан багш Балбын нутагт мэндэлсэн газар анхны суварга, Бурхан Буддагийн гэгээрэлд хүрэх замыг бэлгэдэж хоёр дахь суварга, Бурхан Будда номын хүрд анх эргүүлсэнд зориулж Энэтхэгийн Баранаси хотод 3 дахь суварга, Бурхан Буддагийн эх нас нөхчсөнд зориулж 4 дэх суваргыг, Бурхан Будда рид хувилгаан үзүүлсэнд зориулж 5 дахь суваргыг, Бурхан багш хуврагуудад ном айлдсанд зориулж 6 дахь суварга, Бурхан багшийн насыг уртасгахад зориулж 7 дахь суваргыг, Бурхан Будда нирван дүр үзүүлсэнд зориулж 8 дахь суваргыг тус тус босгожээ. Энэ нь суварга үүсэх эхлэлийг тавьсан.

Суваргыг бүтээх үндэс нь дэлхий ертөнцийн тогтоц бол суваргын мөн чанартай, хүмүүний бие цогцос бол суваргын бүтэцтэй зүй ёсоор зохицолддог гэж үздэг явдал. Иймд “Суварга”-ыг бүтээхдээ хүмүүсийн сайн сайхныг бэлгэдэн шүншиглэж, амьдчилж бүтээдэг.

Монгол суварга нь их хаадын алтан үеэс хойших булш бунхан, туурь, хөшөө зэрэгт голлон хэрэглэгдэж ирсэн. Монголын Хэрлэн Барас хотын тууриас олдсон суваргын үлдэцийг X–XIII зууны үед холбон үздэг. Үүнээс өмнө хүннү, сяньби, жужан, түрэг, уйгар, хятан нарын үеэс сүм дуган шүтээн суварга босгож байжээ.

Монгол суваргын утга, бэлгэдэл нь газар дэлхийг ариун үйлсээр холбох, гэгээрэлд хүрэх замыг бэлгэддэг буддын шашны ариун зүйлс бүхий эрхэм дээд шүтээн юм.

Түлхүүр үгс: суварга, Бурхан Будда, буддын шашин, шашны зан үйл, монголын суварга, шүтээн, суваргын бэлгэдэл, суваргын үүсэл

Symbolism of the Mongolian Stupa

Taivansaikhan Divaa

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Tsezen Jigdengombo ✉

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

✉ j.tsezen.amjilt@gmail.com

Abstract: This article gives a short overview of the origin of the stupa, as well as its form, its elements, and its symbolic meanings. The earliest stupas are linked to significant phases in the life of the Buddha. One of the first was built at his birthplace in what is now Nepal; another marks his enlightenment; a third was erected in Varanasi in India to commemorate his first teaching, known as the turning of the Wheel of Dharma; the fourth stupa dedicated to the Buddha's descent from the heavenly realm after teaching his mother; the fifth stupa commemorating the Buddha's display of miraculous powers; the sixth stupa dedicated to the Buddha's teachings delivered to the monastic community; the seventh stupa symbolizing the prolongation of the Buddha's life; and the eighth stupa commemorating the Buddha's attainment of Parinirvana. These stupas later became the prototype for the development of many subsequent stupas.

The idea behind stupa construction is that the structure of the universe is mirrored in the stupa, while the human body is symbolically expressed in its architectural design.

Therefore, during the construction of a stupa, it is ritually consecrated and symbolically activated to represent the welfare and flourishing of people.

In Mongolia, stupas have been widely associated with tombs, memorials, ruins, and monuments since the period of the great khans. Archaeological remains of a stupa discovered at the ruins of Kherlen Baras city are generally dated to the 10th–13th centuries. Even earlier, during the periods of the Xiongnu, Xianbei, Rouran, Turkic, Uyghur, and Khitan peoples, temples, sacred objects, and stupas were already being constructed.

The symbolic meaning of Mongolian stupas lies in connecting the earth with sacred deeds and representing the path toward enlightenment. Thus, the stupa is regarded as a highly revered sacred object within the Buddhist religious tradition.

Keywords: *stupa, Buddha, Buddhism, religious rituals, mongolian stupas, sacred objects of worship, symbolism of the stupa, origin of the stupa.*

Оршил

Монгол оронд суварга босгох, шүтэх, дээдлэх үзэгдэл олон тааралддаг ч хэдий үеэс, ямар учир шалтгаанаар суварга босгодог талаар энгийн ард иргэд төдийлөн сайн мэдэхгүй юм. Харин нутаг нутгийн ард түмэн “Овоо” босгох, түүнийг тахиx зан үйлийг одоо ч хийсээр байгаа нь бүх нийтийн мэддэг зүйл болжээ. Эдгээрийн аль аль нь орчлон ертөнц, газар тэнгэрийг холбон үзэх, ариун үйлстэй холбоотой

ойлголт юм. Суварга нь буддын шашинтай холбоотой гэгээрэлд хүрэх замыг янз бүрийн ариун үйлсээр илэрхийлдэг бол харин уул овоо тахих нь монголчуудын хувьд бөөгийн шашин, ардын зан үйлтэй холбоотой эртнээс уламжлалтай ойлголт юм. Тиймээс тэнгэр шүтлэгтэй хэмээн нэрлэх нь бий.

Монголд дэлгэрсэн буддын шашны янз бүрийн зан үйлийн дотор “Суварга” босгох, шүтээн болгон дээдлэх явдал Энэтхэг, Төвөд, г.м. бусад ижил шашинт улс орны нэгэн адил өргөн дэлгэр болж хөгжсөн байна. Тэр нь өдгөө монголын түүх, соёлын дурсгалт зүйл, шашны зан үйл, монгол хүний бэлгэдэл бүхий соёлын илэрхийллийг дам дашрамд агуулжээ.

Монгол суваргын онцлог бол монгол газрын мод, шавар, шороо гэх мэт материалаар бүтээн босгосон, түүндээ шингээсэн шүншигтэй, өөрөөр хэлбэл, Энэтхэг төвөдөөс уламжлалтай Суваргын ариун шүтээний агуулгаас гадна Монголд бүтээсэн суваргууд өөрийн гэсэн утга, бэлгэдэлт шинжтэй болсон байна. Харин суваргын гадаад хэлбэр нь мөн л агуулгаа илэрхийлж тэнгэр лүү цойлсон мэт хэлбэртэй /овоо мэт/, 3, 5, 7, 9 г.м. тоон бэлгэдэл бүхий давхаргатай, цагаан өнгийн шавар, тоосгоор хийдэг. Цаашид суваргын төрөл, газар газрын суваргын онцлог, агуулга хэлбэр, монгол суваргын үүсэл хөгжлийн түүхэн төлөв г.м. судлах талбар олон буйг энэхүү оршилд тэмдэглэж байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Эх хэрэглэгдэхүүний хувьд эртний эх сурвалжууд, түүний дотор төвөд ном баримт, Суваргын талаарх судлаачдын бүтээл туурвил болон орчин үеийн ном баримтыг харьцуулж ашигласан болно. МУҮНС болон Гандантэгчилэн, өөрийн хийдийн номын сан хөмрөг дахь буддын шашны зан үйл, үзэл онол, Энэтхэг, Төвөд болон Монгол дахь Суварга шүтээн буй болсонтой холбоотой эх сурвалжид үндэслэлээ.

Мөн Монголд Суварга шүтээн босгох, аравнайлах, зан үйл үйлдэх бүхий л үйл явцад биеэр оролцож ирсэн практик мэдлэг, туршлага дээр тулгуурлав.

Нөгөө талаар Монгол дахь суварга шүтээний өнөөгийн төлөв байдлыг ажиглах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, холбогдох бүтээлийг түүвэрлэн цуглуулах, уншиж судлах зэрэг арга зүйг ашиглав.

Судалгааны үр дүн

Суварга үүссэн тойм: Суваргын гол утга бол бурхан багшийн бие хийгээд түүний айлдсан сургаалийн барилдлага гэж үздэг ба бурхдын чуулдаг газрыг ариун дагшин гэж үздэг учир тэр газар бүтээн босгосон суваргыг газар тэнгэрийн арга билгийн барилдлагыг буй болгодог хэмээх утгаар дараах шинж бүхий томоохон найман суварга анхлан буй болсныг суваргын суурь ойлголт гэж үздэг бөгөөд үүнээс улбаатай бусад олон олон алдартай суваргууд үүсэн хөгжсөн түүхтэй.

Найман шинж бүхий найман суваргад:

Нэг. Эх Майяа Балбын нутагт байдаг Лүмбүний цэцэрлэг хэмээх газар Бурхан багшийг төрүүлсэн хэмээх домогтой. Уг домогт шинээр мэндэлсэн хүүгийн гишгэсэн газар бүр цэцэг ургаж байсан учир энэ газрыг ариун, онцгой газар хэмээн дээдлэн шүтэж суварга босгосон ба “*Бадбүн чоддин буюу цэцгэн овоолгот*” гэж нэрлэжээ.

Хоёр. Бурхан Будда ертөнцийн мөнх бусыг үзүүлэхийн өмнө арван бусын шинжийг өөрийн биеэр арван төрлийн байдлаар үйлдсэний учир гэгээрэлд хүрэх дотоод зам, дадал, ухамсрын төлөвшлийг бэлгэдэж “*Жан чүб чодтэн буюу Бодь мөрийн суварга*” нэртэй шүтээнийг босгожээ.

Гурав. Бурхан багш анх номын хүрдийг эргүүлсэн газар болох Энэтхэгийн Ганга мөрний эрэгт орших Баранаси хотод энх тайвны, гэгээрлийн эхлэл болсон ариун үйл явдлыг дурсан “*Чойхор чодтэн буюу номын хүрдэний суварга*”-ыг босгосон байна.

Дөрөв. Эх Майяа насан өөд болсонд бурхан багш эхийгээ бурхны оронд төрүүлэхийн тэнд очиж ном хураад бууж ирсэн домогт газар “*Лха баб чодтэн /Тэнгэрээс буусан суварга*”-ыг босгосон (гэлэн санваартан нар голлон ном хурдаг газар).

Тав. Энэтхэгийн “Няллён” гэдэг хотод бурхан багш рид (шид) хувилгаанаа үзүүлсэн тухай домогтой бөгөөд түүнд зориулан “*Дүддүл чодтэн*” буюу “*Тэрсүүдийг дарагч суварга*” босгожээ.

Зургаа. Бурхан багш буддын шашны лам, хувраг, санваартны дотор гарсан зөрчилдөөнд зориулж номын ёсыг айлдсан үйл явдлын дурсгалд зориулан “*Гэндүн чодтэн /Хуврагуудын аймгийн суварга*” босгожээ.

Долоо. Бурхан багш насан өөд болохын цагт өөрийн биеэ адислаж насаа уртасгааад шавь нартаа ихээр даган залбирахыг хүссэнд “*Жинлэв Намжил чодтэн /Ариун адист /төгс ялах/*”-ын суварга босгожээ.

Найм. Бурхан багш гэгээрэлд хүрч зовлонгоос ангижран бурхны оронд одсон. Тиймээс Бурхан багш бурхан болохуй - Нирванд орсон үйл явдалд зориулан “*Няндай чоддин*” ба монголоор “Бурхан багшийн нирвааны суварга”-ыг босгосон нь их найман суваргын сүүлчийнх юм.^{1,2}

Хамгийн томоохон суваргуудад Энэтхэгийн Ашока хааны зарлигаар НТӨ III зуунд баригдсан “Санчи” суварга, төвөд болон непалын шашны түүхэнд үнэ цэнтэй /1979 онд ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн/ “Бодхнат” суварга /Катманду, Непалд Y-YI зууны үед байгуулагдсан гэж үздэг/, мөн Мьянмарт /Бирм/ байрлах 4 бурхны шарилыг агуулсан гэх “Шведагон” суварга (анх НТ V-VI зуунд суурь нь тавигдаж хойш хойшдоо олон удаа өргөтгөн босгосон түүхтэй) болон бусад бурхны шашин дэлгэрсэн улс орнуудад томоохонд тооцогдох олон суварга бүтэж буй болжээ (Alexander Csoma de Kőrös 1933; Филипп Стерн 1961; Дэвид Снеллгров 1980; Дилго Кьенце Ринпоче 1990).

Монголын суваргын үүсэл, утга бэлгэдлийн илэрхийлэл

“Суварга” нь санскрит хэлний “*stūpa*”, төвөдөөр “чортэн”, монголоор “суварга” гэсэн үг бөгөөд эртний Энэтхэгээс үүсэлтэй, Бурхан Буддагийн шарил болон ном сургаалийг хадгалах зориулалттай байгууламж байжээ.

¹ Агваанлувансанжамц (V далай лам-1617-1682) “Суварганы мөргөл” судар. 17-р зуун. /Энэ сударт суваргын утга бэлгэдэл, суваргад мөргөх зан үйл, найман суваргын ач тус зэргийг тайлбарлагддаг/ төвд эх, монгол орчуулгатай.

² Буддын найман суваргын тухай анх дурдсан эх сурвалж бол Буддын сургаал номлолын анхдагч эх сурвалж болох Махапаринирвана судар (*Mahāparinirvāṇa Sūtra*), Лалитавистара судар (*Lalitavistara Sūtra*), Буддачарита (*Buddhacarita* – Ашвагхоша), Авадана-шатака (*Avadānaśataka*), Дивьявадана (*Divyāvadāna*) зэрэг юм.

Төвөд хэлний “མཚོད” (чөд/чойд (*mchod*)) гэдэг нь хүндэтгэн өргөх, тахиx гэсэн утгатай, “རྩལ” (тэн /тэдэн (*rten*)) гэдэг нь түшиг, тулгуур, нэгтгээд “མཚོད་རྩལ” буюу чортэн нь тахилгын үндэс буюу тулгуур, бурхны шүтээний дурсгал гэсэн утгаар хэл зүйн үүднээс тайлбарлагддаг. Харин утга зүйн үүднээс авч үзвэл *མཚོད* (*mchod*) – бурхан, гэгээнтэнд өргөх тахил, хүндэтгэлийн илэрхийлэл, *རྩལ* (*rten*) – тухайн тахил, хүндэтгэлийн суурь үндэс гэж үздэг. Иймээс суварга нь үндсэндээ “Бурханы ном, гэгээрлийн ариун дурсгал, тахилгын төв, номын тулгуур” гэсэн гүн утгыг илэрхийлдэг юм.

Эртний монгол бичгийн эх сурвалжид (Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн нарын судалгааны бүтээлээс дэлгэрүүлж үзэж болно) “суварга” (ᠰᠤᠪᠠᠷᠭ᠋ᠠ *[sʊ.ɔ.ɣɑ]*) -ыг “субар”-ᠰᠤᠪᠠᠷ (subar), “суварга”-ᠰᠤᠪᠠᠷᠭ᠋ᠠ (suburga) гэж тэмдэглэдэг бөгөөд энэ нь түрэг хэлний “өндөр, босоо, багана” гэсэн утгаас гаралтай аж, мөн хятад хэлний “塔” “Та, суварга, цамхаг” хэлбэртэй байгууламжийн утгыг илэрхийлэн хэрэглэгдэж иржээ. Тухайлбал, “Мэргэд гарахын орон”-д санскрит *stūpa* гэдэг үгийг “субурган /субар/ суварга” хэлбэрээр тайлбарласан (Жанжаа хутагт Ролбийдорж 1742 /ШУА, Хэл зохиолын хүрээлэн 2021).

Суварга хэмээх үгийн монгол утга нь байгалийн болон байгууламжийн ижил төсөөлөлтэй байдгаараа онцлог бөгөөд монголд суваргын байгууламж буй болсонтой холбоотой зарим газрыг (Зураг 3) “Суварга” хэмээн нэрийдсэн бололтой (*тодорхойгүй*). Энэ нь газрын хөрснөөс дээш сүндэрлэж тогтсон хэлбэрээрээ болон монгол суваргыг бүтээхэд ордог шавар шороон материалд холбогдуулан тодотгож болох юм.

Хүний гараар бүтээсэн байгууламжийн суварга нь ихэвчлэн багана хэлбэртэй, өндөрлөг бүтэцтэй тухайлбал, газар дээр босгосон булш, дурсгалын зориулалттай хөшөө, цогцолборын хэлбэртэй.

Түүхэн байдлаас үзвэл монгол суварга нь их хаадын алтан үеэс хойших булш, туурь, хөшөө зэрэгт голлон хэрэглэгдсэн нэр томъёо юм. Монгол оронд бурхны шашин 4 удаа дэлгэрсний анх түрүүн үе буюу Маодунь Шаньюй (НТӨ 209-174) Лоб нуурын Лоулань, Долоон голын Үсүнь, Алтайн Хуцзу зэрэг орныг эзлэн авснаар бурхны шашин дэлгэрч шүтээн суварга босгох болсон.

Хүннүгийн дараагаар Сяньби зэрэг аймаг хүчирхэгжиж өвөг дээдэстээ зориулан сүм дуган суварга шүтээн босгосон байдаг.³ Сяньби угсааны Тоба “Вэй” (386-535) улсын анхны хаан Тоба Гүй (386-409) өөрийн улсад бурхны шашныг дэлгэрүүлэхийг дэмжиж, бурхны шашны наян гурван ном орчуулан таван давхар суварга босгож байсан ба Тобагийн Юань Вэй улсын үед 6578 сүм, 77258 лам нартай байсан мэдээ тэмдэглэгдсэн бий (Пүрэвбат 2005, 94). Жужан улсын (ҮҮ-ҮІ) үед бурхны шашныг төрийн шашин болгон авснаар лагшин, зарлиг, тааллын шүтээн тоолшгүй бүтээж, Жужаны дараа Түрэгийн хаант улс (ҮІ-ҮІІІ)-д гурван шүтээний сүм хийд байгуулж олон арван ном судар орчуулж байсан, Уйгарын

³ НТ-ын 341 онд Лүн-чен хотод 3 суварга, 514 онд Хөх нуур хавьд таван давхар суварга босгож байжээ. Монголын шүтээн суваргын талаар: Ч.Далай. Монголын бурхан шашны урлаг. Улаанбаатар, Н.Сэр-Од 2005. Монголын сүм хийдийн архитектур. Улаанбаатар, 1999. Буддын шашны нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар

Идигань хаан 760-аад оноос хойш Согдын гар урчуудын тусламжтайгаар суварга шүтээн босгосон, Хятан нар 902 онд бурхны шашны анхны сүм байгуулсан бол 916 он гэхэд Хятаны анхны эзэн хаан Амбяганы ордныхон дээдийн номлол сургаалийг дагаж байв (Пүрэвбат 2005, 95-96).

Монголын дорнод хэсэгт орших Хэрлэн Барас хотын тууринаас 5 болон 7 давхар суварга байсныг илрүүлсэн зэргээс үзэхэд бурхны шашны сүм хийдийг дагалдан олон арван суварга, шүтээн буй болсон байна. 5 ба 7 давхрын тоо нь буддын шашны космологийн ойлголттой холбоотой, мөн шаталсан бясалгалын түвшинг илэрхийлдэг бэлгэдлийн утгатай аж. Энэ нь дундад зууны үеийн Монгол орны хотын туурь бөгөөд судлаачид Х–ХІІІ зууны үе (Кидан болон Монголын эзэнт гүрний эхэн үе)-тэй холбон үздэг (Пэрлээ 1961).

Монгол оронд суварга шүтээн албан ёсоор дахин сэргэсэн үе бол Чингис хаан Төвөд оронд элч илгээж, их Сажи бандида Жэвзүн Дагважалцанд тахилын эдийг өргөн Үйзангаас гурван шүтээнийг залж ирүүлснээр Монгол оронд бурхны шашны сүм хийд, суварга, шүтээн дэлгэрсэн билээ.

1215 онд Чингисийн зөвлөх түшмэл Хятан Юлей Чуцай (1189-1243) болон Чингисийн гуравдугаар хүү Өгөөдэй (1229-1241) нар хамсран 1220 онд Хархорум хотод сүмт Суваргыг байгуулжээ. Асар том байгууламжтай энэхүү суваргыг Мөнх хааны (1251-1259) үед буюу 1256 онд дуусгаж, хожим 1311, 1342-1346 онд тус тус дахин сэргээн үзэсгэлэн төгөлдөр болгосон түүхтэй. ХІІІ зуунаас буддын шашны шүтээний уламжлалаас гадна монголын их хаадын гавьяаг дурсах чиглэл давхар байсан бол ХҮІ зууны сүүлээс хүчтэй дэлгэрсэн буддын шашны нөлөөгөөр монголын суварга шүтээн эрчимтэй хөгжиж, 1586 онд байгуулагдсан “Эрдэнэ зуу” хийд дэх 108 суварга бүтээгдсэн нь одоогийн бидэнд уламжлагдсан Монгол нутаг дахь суваргын томоохон цогцолбор юм.

Суваргын утга, бэлгэдэл нь ихэвчлэн бясалгал хийхэд зориулсан буддын шашны ариун байгууламж хийгээд ариун зүйлс хадгалах зориулалттай, Бурхан багшийн бодийг сэтгэл, гэгээрэлд хүрэх замыг бэлгэдэж эртнээс одоог хүртэл үргэлжлэн хэрэглэгдсээр ирсэн онолын болон бодит практикийн ойлголт болон тогтжээ.

Суварга нь хамаг бурхдын орших орон бөгөөд гадаад хэлбэрээс гадна дотоод мөн чанарын агуу их удвист хүчин зүйлтэй, тэр нь бүхнийг айлдагч Бурханы бэлгэ билгийг илтгэсэн адислага оршиж чадах сайн бүхний хотол чуулган бүрдсэнээр тааллын шүтээн болох бэлгэ чанар төгс болдог хэмээн үздэг байна. Өөрөөр хэлбэл, тааллын шүтээн болох үндэс нь номын лагшингийн шүтээн, сав ертөнц бол ямагт өөрөө бүтсэн суварганы мөн чанартай гэх үзэл; Бурханы лагшин бол суварганы зохион байгуулалттай уялдан зохилддог бөгөөд иймийн учир “Хүмүүний ариусан гэгээрэх үнэн мөрөөр замнахуйд эгэл биеийг бурхан бэлгэ билгийн чанарт хувирган төгөлдөржүүлэх дотоод нууц удвисын шинж бүрэлдэж, *Суварга өөрөө дээдийн гүн номлолыг дүрсэлсэн бэлгэ тэмдгийн номлол, номын лагшин бүхий их шүтээн*” хэмээгддэг билээ. Суварга нь ариусан зүйлийг илэрхийлж байгаа гүн номлол учир утга учиргүй зүйл түүний бүтэц тогтолцоонд байхгүй юм.

Суваргын бүтцэд: Үрийн суварга, Угийн суварга хэмээх 2 гол зүйл буй. Үрийн суваргад номын бие хэрхэн бүтэх сэтгэлийн шатлалыг бүрэн агуулдаг бол, Угийн

суваргад орчлонгоос хэрхэн гэтэлж болох номын агуулга багтдаг. Энэ л мөн чанар нь бурхдын орших орон, тааллын шүтээн болдог байна.

Монголд суварга бүтээх үед дотор нь *тарни бичиг, сүншиг, амин мод, цац* зэрэг зүйлсийг байрлуулж “равнай” өргөдөг зан үйлтэй бөгөөд үүнийг “үрийн суварга” буюу суваргын дотоод шүтээн гэж тайлбарладаг бол, гаднах хэлбэрийг “угийн суварга” (гаднах бэлгэдлийн архитектур) гэж нэрлэх уламжлал бий. Монгол дахь суваргын урлаг, бэлгэдэл, бүтцийн тухай болон буддын шавран болон чулуун суваргуудын онолын тайлбар, түүний архитектурын бүтэц, бэлгэдлийн агуулгын тухай бичсэн бүтээлд дэлгэрүүлэн үзэж болно (Meinert Carmen (ed.), Andrey Terentyev 2011). Харин хүний гараар босгосон суваргын бэлгэдэлт бүтээн байгуулалтаас өмнө монголчууд тэнгэр, газар, уул, ус, овоог байгалийн хүчний оршихуйн эх үүсвэр хэмээн үзэж, зөн билэг, тахил мөргөл үйлдэж ирсэн бөөгийн шашны зан үйл бий билээ. Ялангуяа **овоог** шашны, газар нутгийн бэлгэдэл, тахилгын төв болгон ашиглаж, тахилга, тайллага үйлдэн, бэлгэдлийн үйл ажиллагаа явуулдгаараа суваргын шүтээнтэй ойролцоо. Энэ талаар монголын шашин, шүтлэг, нийгмийн өөрчлөлтийн талаар судалдаг Каролин Хамфри /Caroline Humphrey/-ийн “*Shamans and Elders: Experience, Knowledge, and Power among the Daur Mongols*” бүтээлийн “*Shamans and Shamanism*” (Шамануудын зан үйл, тэнгэр шүтлэг, овоо, байгалийн оршихуй, 5-р бүлэг), “*Shamans in Society and History*” (Овооны орон зай, нийгмийн зан үйл, тэнгэрийн хүчний холбоо, 6-р бүлэг) (Humphrey, Onon 1996, 396) хэсэгт үзнэ үү.

Суваргын мөн чанарын талаарх онолын бүтээлд орчлон ертөнцийн тогтоц бол суваргын мөн чанартай, хүмүүний бие цогцос бол суваргын бүтэцтэй, гадаад ертөнцийн бүтэц хүний биеийн бүтэц хоёр мөн жам ёсны зохицолдолгоотой хэмээх үзэл нотолгоо байдаг учир, “Суварга” бол хүмүн төрөлхтний сайн сайхныг бэлгэдсэн цогц зүй тогтолт ойлголт учир суваргыг цогцлоон бүтээхдээ үзэл, онолын зохирол, нарийн нягт арга ажиллагаагаар шүншиглэн амьдчилж бүтээдэг жамтай.

Буддын шашнаар дамжсан монгол суваргын утга бэлгэдэл бол дээрхийн нэгэн адил “бүх амьтны зовлонг ариусгах, номын үйлийг дэлгэрүүлэх” зорилготойгоор босгосон буян номын төв гэсэн утгыг агуулж ирсэн бөгөөд үүссэн цагаасаа өдгөөг хүртэл өөрийн мөн чанараа хадгалсан ариун газар, түүх соёлын дурсгал болон өвлөгджээ.

Монгол суваргын онцлог бол газар нутгийн онцлог бүхий *цагаан суварга, шавар, тоосгон* хийцтэй болсон нь түгээмэл юм. Өөрөөр хэлбэл, энэтхэг төвөдөөс уламжлалтай суваргын ариун шүтээний агуулгаас гадна Монголд бүтээсэн суваргууд өөрийн гэсэн утга, бэлгэдэлт шинжтэй болсон байна. Тухайлбал, монголын “*Цагаан суварга*” гэдэг нь монголчуудын уламжлалт “Цагаан” өнгөний бэлгэдэлд (цагаан сэтгэл, цагаан сүү, цагаан зам г.м.) үндэслэн ариун чанар, энэрэл нигүүлсэл, билэг ухаан, амар амгаланг бэлгэдэж цагаан өнгөөр шохойдсон суваргыг босгож иржээ. Энэ нь зөвхөн цагаан өнгө төдий бус, хийц-өнгө-бэлгэдлийн уламжлалт хэв маяг ажээ. Мөн цагаан суварга нь гай барцдыг номхотгож, орон нутгийг ариусгах утгатай байсан байна. Иймээс монголын цагаан суварга нь зөвхөн Буддагийн дурсгал төдий бус, орон зайн адислал, хамгаалалт тогтоох үүрэгтэй “шашин-соёлын хамгаалалтын тэмдэглэгээ” юм. Ялангуяа шавар, тоосго,

чулуу зэрэг орон нутгийн материал ашигласан зэрэг нь орон нутгийн соёлд уусган нутагшуулсан монгол суваргын илрэл харагддаг (Содномпил 2015; Майдар 1972).

Эрдэнэ зуугийн 108 суварга ч (зарим хэсэг нь) мөн цагаан суваргад орох бөгөөд энэ нь зөвхөн шашны байгууламж төдий бус, монголын соёлын өв, бэлгэдэлт сэтгэлгээний илэрхийлэл хэмээн авч үзэх нь зүйтэй.



Зураг 1. Эрдэнэ зуу. 108 суварга /Зургийг цахимаас авч ашиглав/



*Зураг 2. Бээжингийн “Цагаан суварга”
(Монголын ван Лам Чойзенгийн
захиалагаар 1271–1279 онд
(Юань гүрний үед) баригдсан*

Монголын шавар, тоосгон хийцтэй суварга нь дөрвөлжин суурьтай, зууван эсвэл цилиндр хэлбэртэй, оройдоо дээд талын бөмбөлөг туурь бүхий монгол нутаг, нүүдлийн соёлд зохицсон архитектурын шийдэл болдгоороо монгол онцлогтой суварга юм.

Утга бэлгэдэл нь цагаан шохойгоор бүрж, суваргын хэлбэрээр бий болгосноор сэтгэл ариусгах; орон нутгийн дотоод амар тайван, энэрэл нигүүлсэл бэлгэдэхээс гадна орон нутгийн байгальд зохицсон шавар, тоосгон бүтэц нь гай гамшиг, муу энергийг саармагжуулах бэлгэдэлтэй. Мөн Төвөдийн чоддины хэлбэрийг ашигласнаар буддын сургаал ном, буян үйлдэхийг илэрхийлж, лам хувраг, нэрт хүний алдар гавьяаг дээдлэх шүтээн болон ашиглагддаг.



Зураг 3. Дундговь аймаг, Өлзийт сум

Харин цагаан суваргын байгууламжийг хийдэг монгол нутгийн шавар эрдсийг суварга шүтэнтэй зүйрлэн мөн “Цагаан суварга” гэж нэрлэх нь бий. Мөн Монгол Улсад байдаг байгалийн үзэсгэлэнт газрын нэг, алсаас харахад буддын суварга мэт давхарласан, цамхаг маягийн шаварлаг тунамлаас тогтсон чулуулаг давхарга бүхий тогтоцтой газрыг зүйрлэн нэрлэсэн нь буй. Жишээ нь, Дундговь аймаг, Өлзийт сумын нутагт орших “Цагаан суварга” нэртэй байгалийн дурсгалт газар нь

цайвар, цагаан-шаргал өнгийн шаварлаг, шохойн чулуун давхаргатай бөгөөд эрт үед нуур, тэнгисийн ёроолд хуримтлагдсан шавар, шохойн давхарга нь салхи, усны элэгдлээр олон мянган жилийн турш хэлбэржжээ. Хэдийгээр хүний гараар бүтсэн шашны суварга биш боловч монголчуудын ойлголтоор ариун, цэвэр, бэлгэ дэмбэрэлтэй газар гэж үзэн “Суварга” шүтээнтэй зүйрлэн нэрлэсэн. Энэ мэт Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай зэрэг аймагт буддын суваргатай төстэй дүрс бүхий цайвар, шаргал тунамал чулуулгын давхаргатай “Цагаан суварга”-ууд нь тогтоцын хувьд нэн эрт үед хамаарч, агуулгаараа монгол соёлд ижил бэлгэдэлтэй гэж үзэж болох юм.

Монголчууд суварга шүтээнээ амьтай гэж үздэг нь бэлгэдлийн шинжтэй. Үүнийг Суваргын шүншиг - *ཤུང་ཞིག / ཤུང་ཤིག་མཛོད* – (shung zhik /shung shig) хэмээх ойлголтоор уламжилж ирсэн. Өөрөөр хэлбэл, суваргын дотор “оршуулж, адислан шингээдэг ариун агууламж”-ийг хэлнэ. Энэ нь суваргыг жинхэнэ утгаар нь “*амь оруулах*” шашны ёслолын цөм юм.

Ерөөс монголчуудын байгаль дэлхий, юмс үзэгдлээ амьдчилж үздэг, түүнийгээ эрхэмлэн дээдэлдэг үзэл нь монгол суваргын амин сүнснийг утга-соёл-бэлгэдэл-сүсэг бишрэлийн нэгдмэл чанараар бүтээсэн гэж үзэж болно. Тухайлбал, Эрдэнэ зуугийн 108 суварга нь Монгол орны нэр бүхий газар нутагт “буян хураах, саад тогторыг арилгах” үүднээс бүхнийг хамарсан төгс тоо 108, цагаан өнгөний бэлгэдэл бүхий тэнгэр газрыг холбосон ариун шүтээн болгон босгожээ.

Суваргын шүншигт 3 гол зүйл орно. Биеийн шүтээн буюу бурхны дүр бүхий баримал, Зарлигийн шүтээн буюу 108 номын судал, 108 тарни, эрдэнийн үр, Сэтгэлийн шүтээн буюу алт, мөнгө, шүр сувд г.м. долоон эрдэнэ, үр тариа зэргийг бэлгэдэн суваргын төв тэнхлэгт доороосоо дээш амьсгалын судас мэт байрлуулж оруулдаг. Шүншигийн эд зүйлсээ ариусгаж, адислах, байрлуулах, амилуулах бүх үйлдэл тогтсон дэг жаягтай. Нэгэнт амин сүнс буй болсноор суваргын бие-хэл-сэтгэлийн шүтээн болж төгөлдөржинө. Иймд Монгол оронд, монгол хүний ур ухаан, сэтгэл оюун, сүшиг бишрэл, эд зүйлсээс бүтсэн шүтээн суварга нь “Монгол суварга”-ын утга соёл, бэлгэдлийн цогцолбор болж дэлгэрэн хөгжсөн байна.

Суваргын хэлбэр

Суваргын гадаад хэлбэр нь дотоод агуулга, бэлгэдлээ мөн илэхийлдэг. Оройн цамхаг хэлбэр нь дэлхийн төвөөс тэнгэр рүү тэмүүлэх дээд гэгээрлийг эрэлхийлэх замыг илэрхийлсэн бэлэг тэмдэг бүхий агуулга, хэлбэрийн нэгдэл юм.⁴ Олон давхарласан, өрсөн, шаталсан хэлбэр нь бие, хэл, сэтгэлийн шат шатны гэгээрэл, нар, сар, од гаригстай зохицсон энергийн түвшинг илтгэнэ.

Суваргын суурийн хэлбэр нь гурвалжин бол бие, хэл, сэтгэлийн гурвал, дөрвөлжин бол тухайн юмсын тогтвортой оршихуйн шинжийг бэлгэддэг.

Монголын онцлогтой цагаан өнгийн суварга бол ариун гэгээн, зовлонгүй цэвэр утгыг илтгэнэ. Эцэст нь багана буюу суваргын тулгуур хэсэг ба бусад нүх, хонх зэрэг нь мөн л үзэгдэж харагдах хэлбэр боловч суваргын сүнстэй холбоотой

⁴ Суваргын хэлбэр, нэршил, бэлгэдлийг илүү системтэй тайлбарласан бүтээлд Чойжунг (*Chos byung* – Буддын шашны түүх) – Бутон Ринчендруб, Буддын шашны дэлгэр түүх (*Deb ther sngon po*) – Гой Лодой Жонну, Пагсам Жонзанг (*Pag-sam-jon-zang*) – Сумба хамбо Ишбалжир зэрэг бүхэлдээ орно.

хийгддэг, эрч хүч, дуу авиа, энергийг бэлгэдэж буй агуулгаа илэрхийлсэн, Цагаан – ариун, гэгээн, Алт, мөнгө – гэгээрэл, тансаг байдал, чулуулаг шавар зэрэг – тогтвортой байдлыг бэлгэдсэн өнгөний сонголт голлосон нь монгол суваргын онцлог юм.

Суваргын ач холбогдол

Юуны өмнө буяны их үйлсийг бүтээх, энэ насны нүглээс гэтэлгэж нас уртасгах, хойд насанд дээд төрөлд төрөх, сэтгэлийг ариусгах, эв нэгдлийг бэхжүүлэх, улс нийгмийн соёлын өв, зан заншил, бэлгэдлийн дархлааг хадгалахад ач тустай юм. Ялангуяа буддын шашинд буян номын ёсыг эс сахисан, элдэв нүгэл хилэнц үйлдсэнийг засах, ариусгах, номын ёсыг эрхэмлэж, шүтэн суваргыг дээдлэх, залбирал мөргөл үйлдэх зэргээр төөрөгдлөөс аврагдах, гэгээрэлд хүрэхэд туслах олон зан үйл, сургаал номлолыг сургадаг байсан нь өнөө цагт ёс суртахуунд эергээр нөлөөлөх боломжтой.

Суварга нь ариун шүтээний шинжийг ямагт агуулдаг учир түүнийг босгох газар орон хийгээд жил, сар, өдөр нь бэлгэдэл төгс байхыг сонгох, бүтээн үйлдэгч нар нь ариун номын адистай байх, суварга босгох, сэргээх бүхий л үйл ажиллагаанд оролцох нь буяны үйлс болдог билээ. Суварга босгоход бүх талаар оролцох, шүтээн шүншигт өөрийн хувь нэмэр оруулах нь олон нийтийн сайн үйлсийн шинжтэй бөгөөд бүтээн босгосон хойноо ч шүтэн дээдлэх, хайрлан хамгаалах зэргээр сэтгэлийн ариуслыг олдог ач тустайг ухааруулан ойлгуулах ёстой.

Суварганы гоёл чимэглэл, эд зүйлийг урлан үйлдэгчид энэ болон хойд насандаа мэргэдийн эрдмээр чимэгдэж, даган баяссагч, залбиран шүтэгч нарын ариун үйлсэд дээдийн буян болно. Бүтээсэн суваргыг хүндэтгэн тойрч маань тарни хөгжөөх, тахил өргөх, зул, хүж барих нь цаглашгүй их буян хураадаг хэмээн номлодог учир түүний ач тус болой. Харин сүүлийн үед шүтээний мөн чанар, ач тусын тухай ойлголт алдагдаж, хэн дуртай хүн, хаа тааралдсан газраа суварга босгож, нөгөө гэгээн ариун үйлсийн утга учрыг үнэгүйдүүлэх явдал ажиглагдаж буй тул ариун дагшин газрыг өдөр судартай нь зохицуулан зүйд нийцүүлж босгох нь зөв санагдана.

Дүгнэлт

Бид “Суварга”-ын тухай ерөнхий ойлголттой ч, түүний гарал үүсэл, мөн чанар, агуулга, бэлгэдэл, бүтээцийн соёлын илэрхийллийг тэр бүр нарийн сайн мэдэхгүй билээ. Ялангуяа Монгол газар босгосон “Суварга”-ын олон арван байгууламжийг тусгайлан судалж бичсэн нийтлэл ховор байна. Энэхүү өгүүлэлд суваргын тухай ерөнхий ойлголт гарал үүсэл, агуулга, хэлбэр, монгол суваргын талаарх товч ойлголт өгөхийг зорьсон болно. Энэтхэг, төвөдөөс уламжлалтай буддын шашин дэлгэрсэн улс орнуудад суварга өргөн дэлгэр тархсан бөгөөд агуулга, ач холбогдол, бүтээх, шүншиглэх, шүтэж дээдлэх бүхий л зан үйл нь нийтлэг юм. Өөрөөр хэлбэл, суварга нь буддын шашны ариун байгууламж хийгээд ариун зүйлс хадгалах зориулалттай, Бурхан багшийн бодийг сэтгэл, гэгээрэлд хүрэх замыг бэлгэдэж эртнээс одоог хүртэл үргэлжлэн хэрэглэгдсээр ирсэн онолын болон бодит практикийн ойлголт болон тогтжээ.

Буддын шашнаар дамжсан монгол суваргын утга бэлгэдэл бол дээрхийн нэгэн адил “бүх амьтны зовлонг ариусгах, номын үйлийг дэлгэрүүлэх” зорилготойгоор босгосон буян номын төв гэсэн утгыг мөн агуулж ирсэн бөгөөд үүссэн цагаасаа өдгөөг хүртэл өөрийн мөн чанараа хадгалсан ариун газар, түүх соёлын дурсгал болон өвлөгджээ.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Агваанлуvsанжамц (V далай лам 1617-1682) XVII зуун. *Суварганы мөргөл судар*.

Буддын шашны нэр томъёоны тайлбар толь. 1999. Улаанбаатар.

Дамдинсүрэн, Ц. 1986. *Монгол үсгийн тайлбар толь*. Улаанбаатар.

Жанжаа хутагт Ролбийдорж. 1742. *Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг*. (ШУА, Хэл зохиолын хүрээлэн. 2021. *Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг*. Улаанбаатар.)

Майдар Д. 1972. *Монголын архитектур ба хот байгуулалт*. Улаанбаатар.

Пүрэвбат, Г. 2005. *Их Монголын суварга: Онол хийгээд бүтээх ёс*. Сөүл хот.

Пэрлээ, Х. 1961. *Монголын эртний хот суурины товчоон*. Улаанбаатар.

Ринчен, Б. 1964. *Монгол үсгийн хэлний толь*. Улаанбаатар.

Содномпил, Б. 2015. *Монголын буддын архитектур, бэлгэдэл*. Улаанбаатар.

Сэр-Од, Н. 2005. *Монголын сүм хийдийн архитектур*. Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Alexander Csoma de Kőrös. 1933. *The Stupa: Its Religious, Historical and Architectural Significance*. London.

Humphrey C., Onon U. 1996. *Shamans and Elders: Experience, Knowledge, and Power among the Daur Mongols*. Oxford: Oxford University Press.

Meinert, C. (Ed.), Terentyev, A. 2011. *Buddha in the Yurt: Buddhist Art from Mongolia*. Munich: Hirmer Verlag.

Дилго Къенце Ринпоче. 1990. *The Eight Great Stupas*. Boston.

Дэвид Снеллгров. 1980. *Tibetan Buddhist Architecture and Its Symbols*. London.

Филипп Стерн. 1961. *The Buddhist Stupa in India and Central Asia*. Paris.